



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/178

Бат-Өлзий сум

Гал унтраах баг шинээр байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд гал түймрийн аюул тохиолдсон үед гал унтраах, их хэмжээний газар нутаг хамрахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Д.Очирхуяг (Ойн ангийн дарга)

Н.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

А.Мягмардагва (Ойн инженер)

Ө.Гөлгөө (Улсын бүртгэгч)

Д.Мөнх (Цахилгаан шугам сүлжээний салбарын эрхлэгч)

М. Баатарчулуун (Цахилгаан шугам сүлжээний салбарын техникч)

Г.Дашдондов (Ерөнхий боловсролын сургуулийн багш)

Д.Баярсайхан (Ерөнхий боловсролын сургуулийн багш)

Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

Т.Анхбаяр (Ерөнхий боловсролын сургуулийн сантехникч)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

М.Бат-Өлзий (Засаг даргын Тамгын газар нярав)

2. Гал түймэр унтраах багийн гишүүдийг чадавхжуулах сургалтанд хамруулж, техник хэрэгслээр ханган, байнгын бэлэн байдалд бэлтгэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын "Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулах тухай" 2017 оны А/109 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

627301369